



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/443

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "б", Төсвийн тухай хуулийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2.4, 13.2.5, 32 дугаар зүйлийн 32.1.1, аймгийн Засаг дарга Монгол Улсын Шадар сайдтай 2021 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн хамтран ажиллах гэрээний 3.7 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийг зориулалт зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус аймгийн нутаг дэвсгэрт үүсч болзошгүй гамшгийн нөхцөл байдлыг даван туулах, нэгдсэн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох зорилгоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах "Команд штаб"-ын сургуулийг 2021 оны 10 дугаар сард багтаан зохион байгуулсугай.

2.Гамшгаас хамгаалах "Команд штаб"-ын сургуулийг зохион байгуулахад шаардагдах зардал 26,973,000 (хорин зургаан сая есөн зуун далан гурав) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Ганболд)-зөвшөөрсүгэй.

3.Дээрх хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж хяналт тавьж ажиллахыг аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга дэд хурандаа (Д.Одонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101005

D:My Doc. Zahiramj. Zasag darga